

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2024 ОНЫ 02 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ**

2024 оны 03 дугаар сарын 07

Улаанбаатар хот

№	Үүрэг даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг даалгавар НЭГ: Боловсролын салбарын сургалтын чанар, стандартыг бодлогын түвшинд сайжруулах, хүний хөгжлийг хангах чиглэлээр хөтөлбөр боловсруулж танилцуулах.				
1	Боловсролын салбарын сургалтын чанар, стандартыг бодлогын түвшинд хэрэгжүүлэх, багшийн тасралтгүй хөгжил, сургалтын байгууллагын менежментийн өөрчлөлтийг боловсронгуй болгож, боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, хүүхдийн сурч, хөгжих эерэг таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дүүргийн ИТХ-аас 2021 онд баталсан “Чадварлаг багш-2024” хөтөлбөрийг 4 зорилт 15 арга хэмжээний хүрээнд төлөвлөн хэрэгжүүлж ажиллаж байна.			70
Үүрэг даалгавар ГУРАВ: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 оноос хойш хэрэгжиж буй 30 сургууль, цэцэрлэгийн барилгын ажлыг эрчимжүүлэх, шийдэл гаргах уулзалтыг зохион байгуулах.				
2	Дүүргийн хэмжээнд улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 оноос хойш хэрэгжиж буй 30 сургууль, цэцэрлэгийн барилгын ажлыг эрчимжүүлэх, шийдэл гаргах уулзалтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж дүүргийн Засаг даргын орлогч Л.Цэеэрэгзэн дүүргийн хэмжээнд нийт 6 сургууль, цэцэрлэгийн барилгын ажлын явц удаашралтай байгаа талаар танилцуулсан. Үүнд: ➢ Ерөнхий боловсролын 145, 149 дугаар сургууль, 277 дугаар цэцэрлэгийн цогцолборын ажил 100% дуусаж 2020-2021 оны хичээл сургалтын үйл ажиллагаагаа эхлүүлсэн. ➢ 4 дүгээр хорооны 5-р сургуулийн өргөтгөлийн барилгын ажил - 95%, ➢ 12 дугаар хорооны 144 дүгээр сургууль, 276 дугаар цэцэрлэгийн цогцолборын барилгын ажил - 95% ➢ 16 дугаар хорооны цэцэрлэгийн гүйцэтгэл - 80% ➢ 19 дүгээр хорооны сургууль, цэцэрлэгийн цогцолборын ажил - 80% ➢ 8 дугаар хороо болон 13 дугаар хорооны цэцэрлэгийн барилга баригдахаар газар чөлөөлөлтийн ажил явагдаж байна.			100

Үүрэг даалгавар ЗУРГАА: “Тохижилт бүтээн байгуулалтын жил”-ийн ажлын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг нийслэл болон дүүргүүдэд хийх тохижилтын ажлуудтай уялдуулан боловсруулж танилцуулах.				
3	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/01 дүгээр захирамжаар 2024 оныг “Тохижилт бүтээн байгуулалтын жил” болгон зарласны хүрээнд дүүргийн хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 19 байршилд тохижилтын ажил 600,0 сая төгрөг, дүүргийн урсгал зардлын хөрөнгөөр 25 байршилд 400,0 төгрөгөөр явган замын ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байна. Тохижилт бүтээн байгуулалтын жилийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны Тохижилт, ногоон байгууламж, орчны бохирдлын асуудал хариуцсан хяналтын мэргэжилтэнд егр цахим хаягаар хүргүүлсэн.			100
Үүрэг даалгавар НАЙМ: Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс барилга, угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг сайтар хангах.				
4	Нийслэлийн Засаг даргын 2024 оны хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр: ➤ Дүүргийн 19 дүгээр хороо, “Хорооны цогцолбор барилга барих ажил” ЧДХААА.ДТХ.А22/32 тоот гэрээтэй ажил гүйцэтгэгч “Гегатера Тех” ХХК нь барилгын ажлыг 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдөр эхэлж 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Ажлын явц 50 хувийн гүйцэтгэлтэй; ➤ Дүүргийн 19 дүгээр хороо, “Нийтийн тээврийн эцсийн зогсоолын тохижилтын ажил” ЧДХААА.ДТХ.А23/33 тоот гэрээтэй ажил гүйцэтгэгч “Нано экологи” ХХК нь тохижилтын ажлыг 2023 оны 10 сарын 30-ны өдөр эхлэсэн бөгөөд гэрээний хугацаа сунгах хүсэлтийг өгсөн. Ажлын явц 90 хувийн гүйцэтгэлтэй; ➤ Дүүргийн 22 дугаар хороо, “Хорооны цогцолбор барилга барих ажил” ЧДХААА.ДТХ.А23/35 тоот түлхүүр гардуулах гэрээтэй ажил гүйцэтгэгч “Эйч Ар Ви констракшн” ХХК нь барилгын ажлыг 2024 оны 02 дугаар сарын 02-ний өдөр эхэлж 2024 оны 12 дугаар сарын 30-ний өдөр ашиглалтад оруулахаар төлөвлөж одоо ажлын зургийн гүйцэтгэлийн шатанд явж байна; ➤ Дүүргийн 6 дугаар хороо, “66, 67, 68, 60-1 дүгээр байрны дээвэр засварын ажил” ЧДХААА.ДТХ.А23/34 тоот гэрээтэй ажил гүйцэтгэгч “Дэлгэрмөрөн групп” ХХК нь засварын ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр эхэлж 2023 оны 12 дугаар сарын 30-ны өдөр дуусгахаар төлөвлөсөн боловч тус гэрээ нь хүйтний улиралд батлагдсан тул ажлыг 2024 оны 04 дүгээр сард эхлүүлэхээр гэрээг сунгасан байна. ➤ Дүүргийн 15 дугаар хороо, “Хорооны цогцолбор барилга барих ажил” ЧДХААА.ДТХ.А23/23 тоот гэрээтэй ажил гүйцэтгэгч “Рок гранд” ХХК нь барилын ажлыг 2023 оны 12 дугаар сарын 15-ний өдөр эхэлж 2024 оны 09 дүгээр сарын 31-			100

	ний өдрийн дотор ашиглалтад оруулахаар төлөвлөж зургийн ажлын гүйцэтгэлийн шатанд явж байна; ➤ “Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” ОНӨТҮГ-ын 2024 оны батлагдсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалтын ажлуудын зураг төсөв боловсруулах ажлууд тус тус хийгдэж байна.			
Үүрэг даалгавар АРАВ: Нийслэлийн хэмжээнд гэмт, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр ажлуудыг зохион байгуулах.				
5	1. Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 13/91 дугаартай албан бичгээр гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон бусад хууль тогтоомжийн чиглэлээр мэдлэг олгох сургалт авах хүсэлт ирүүлсний дагуу 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн онцгой байдлын офицер бүрэлдэхүүнийг чадавхжуулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулагдсан чуулга уулзалт - зөвлөгөөнд “Жендер ба хүний эрх, гэр бүлийн хүчирхийлэл гэж юу вэ ямар хэлбэрээр илэрдэг вэ?”, “Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг түүний хор уршиг, урьдчилан сэргийлэх чиглэлээр авах хариу арга хэмжээ” сэдвээр 116 офицер алба хаагчдад 2 цагийн сургалт мэдээлэл хүргэн ажилласан. 2. Дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Заяа гэгээний Гүшиг дацан” хийдийн 10 сурагчдад насан хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчилд хохирч, холбогдохоос урьдчилан сэргийлэх, сургуулийн орчинд үе тэнгийн дээрэлхэлт, дарамтыг эрт шатанд илрүүлэх, таслан зогсоох зорилгоор “Үе тэнгийн дээрэлхэлт”, “Жендерийн тухай ойлголт” сэдвүүдээр яриа, таниулга хийн мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. 3. Хичээлийн жилийн 2 дугаар улирал эхэлсэнтэй холбогдуулан гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирч болзошгүй үйлдэлд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн 8-12 дугаар ангийн сурагчдын дунд “Мэдье, сонсьё, сэргийлье” сэдэвт сургалтыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран 900 гаруй сурагчдад зохион байгуулан ажилласан. 4. Дүүргийн 10-19, 21-24 дүгээр хороодын нийтийн эргүүл, олон нийтийн байцаагч нарыг өдрийн цагаар гудамж талбайд үйлдэгдсэн, үйлдэгдэж болзошгүй тодорхой цагаар хороо хариуцсан цагдаа, олон нийтийн цагдаа нарын хамт нийт 76 удаагийн давтамжаар 276 иргэнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл хүргэн ажилласан.			100

	5.“Сэрэмжлүүлэг” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаарт удаа дараагийн давтамжтай дуудлага мэдээлэл өгдөг айл өрх, аж ахуй нэгж байгууллагын судалгааг гарган дүүргийн 11, 16 дугаар хороодын иргэний танхимд удаа дараа дуудлага мэдээлэл өгдөг иргэд болон эрүүлжүүлэх саатуулах байранд орсон иргэдэд “Зөв дадал” төрийн бус байгууллага, дүүргийн “Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн хэлтэс”-тэй хамтран 209 иргэнд сургалт орж 15 ширхэг зурагт хуудас тараан ажилласан.			
Үүрэг даалгавар АРВАН НЭГ: Барилга угсралтын ажлын явцад гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, барилгын норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулж, орчин тойрны өнгө үзэмжийг сэргээлгэх ажлыг зохион байгуулах.				
6	“Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” ОНӨТҮГ-аас бүтээн байгуулалт, барилга угсралтын ажлын явцад Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулахаар Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрмийг баримтлан ажиллаж байна. Энэхүү дүрмийг барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх шинэчлэх буулгах, сэргээн засварлах тоноглох, техникийн шинэчлэлт хийх барилгын материалын бүтээцийн үйлдвэрлэл машин механизм, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа эрхлэгч аж хуйн нэгж байгууллага харьяалал өмчийн хэлбэр харгалзахгүйгээр заавал дагаж мөрддөг. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай, Хөдөлмөрийн тухай, Барилгын тухай, Галын аюулгүй байдлын тухай, Эрүүл ахуйн тухай хууль тогтоомж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартууд барилгын норм ба дүрэм, Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын 148, 155, 167 дугаар конценцид заасан нэр томъёог хэрэглэн ажиллаж байна. Барилгын ажлын эхлэхийн өмнө захиалагч, гүйцэтгэгч хамтран тухайн төсөл арга хэмжээний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан эрсдэлээс урьдчилан сэргийлж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулахтай холбогдон гарах зардлыг тооцон харилцан зөвшилцсөний үндсэн дээр ажил гүйцэтгэх гэрээний гол хавсралт, мөрдлөг болгон Эрсдэлийн менежмент MNS ISO 31000 2017 стандартын дагуу ажиллаж байна. “Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” ОНӨТҮГ-аас 2024 онд бүтээн байгуулалт, барилга угсралтын 7 ажил гүйцэтгэж тухай бүрд орчны цэвэрлэгээг хийж “Чингэлтэй ТҮК”-д ачуулан тээвэрлүүлж орчны өнгө үзэмжийг сэргээх ажлыг хийж ирсэн.			70
Үүрэг даалгавар АРВАН ХОЁР: Шар усны үер болон хөрсний ус, халиа дошингоос урьдчилан сэргийлэх, үүссэн нөхцөл байдлыг шуурхай арилгах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх, далан сувгийн цэвэрлэгээний ажлыг эрчимжүүлэх.				

7	Дүүргийн хэмжээнд халиа дошин, шар усны үерээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлэн хамтран зохион байгуулан ажиллаж байна. ➤ Дүүргийн 10,12 дугаар хороодын халиа дошин үүссэн байршлуудад 2024 оны 02 дугаар 29-ний өдөр Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Лхагвасүрэн нөхцөл байдалтай танилцаж үүрэг чиглэл өгч ажилласан. ➤ 2024 оны 03 дугаар сарын 04-ны өдөр дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрийн “Ачтан” дэлгүүрийн баруун талын гүүр битүүрсэн. Мөн 17 дугаар хорооны 50 дугаар гудамжны айл өрхүүдэд шар ус орохоос хамгаалж мөсөн далан босгож, суваг шуудуу татах ажлыг дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 2 алба хаагч, 1 тээврийн хэрэгсэл, “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК-ийн 2 инженер техникийн ажилтан, 1 машин механизмтайгаар гүүрний сувгийг нээж шуурхай ажиллаж байна. Мөн дүүргийн хэмжээнд үүссэн халиа дошин, шар усны үерээс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 5 удаа ярилцлага өгч урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан. ➤ Дүүргийн 17 дугаар хорооны Сурагчийн 47 дугаар гудамж, 23 дугаар хорооны Сурагчийн 50, Баянхайрханы 4 дүгээр гудамжинд үүссэн халиа тошинг машин механизмаар суваг татаж урсацыг чөлөөлөн илүүдэл мөсөөр далан босгож ажилласан. ➤ Нийслэлийн Онцгой комиссын 2024 оны 04 дүгээр хурлын тэмдэглэл, "Гамшгийн шар түвшин тогтоох тухай" 01 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дүүргийн 11 дүгээр хороо, Дэнжийн 1000-н 3-р сувагт үүссэн халиа дошингын мөс тээвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. ➤ Дүүргийн 10 дугаар хороо, Дэнжийн 1000-н 1-р суваг (39-р сургуулийн урд тал)-т үүссэн халиа тошин авто зам болон явган замын зорчих хэсэг рүү хальсан тул Нийслэлийн Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-ын шуурхай дуудлагын 77200200 дугаарын утсанд мэдэгдэж, авто зам, явган замын зорчих хэсэгт үүссэн мөсөн дээр “Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээ” ХХК-аар давс бодис цацуулан ажилласан.			100
Үүрэг даалгавар АРВАН ДӨРӨВ: Үерийн эрсдэлтэй бүсэд байгаа айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг нүүлгэн шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх.				
8	Дүүргийн Онцгой комиссоос Газар зохион байгуулалтын албатай хамтран эрсдэл бүхий 135 айл өрхөд мэдэгдэл өгч урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан, мөн үерт өртөх эрсдэл бүхий 3 айл өрхийг нүүлгэн шилжүүлж ажиллалаа.			70

	Дүүргийн 7-24 дүгээр хороодын нутаг дэвсгэрт шар усны үерийн эрсдэлд орох эрсдэл бүхий 130 өрхийн судалгааг гаргасан. Тухайн өрхүүдэд болон дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст тус тус хүргүүлэн ажилласан.			
Үүрэг даалгавар АРВАН ДОЛОО: Албан тушаалтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах, ажлын байранд архидан согтуурахгүй байх, ажлын цаг ашиглалт, бүтээмжийг сайжруулах, гүйцэтгэл үр дүнг тооцож ажиллах.				
9	Албан хаагчдын цагийн бүртгэлийг цаг бүртгэлийн системээс татан авч, удирдлагад танилцуулан ажиллаж байгаа бөгөөд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Дотоод журмын 12.2 дахь хэсгийг үндэслэн ажлаас хоцорсон 1 минутыг 100 төгрөгөөр тооцож, 60 минутаас дээш хоцорсон тохиолдолд 1 минутыг 500 төгрөгөөр тооцон цалингаас суутгах арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 2024 оны 1 болон 2 дугаар сарын цаг ашиглалтад хяналт шинжилгээ хийж байна. Албан хаагчдын ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор хэрэгцээтэй байгаа сургалтыг тодорхойлж Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран сар бүр холбогдох сургалтуудад хамруулан ажиллаж байна. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмын дагуу албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хагас бүтэн жилээр үнэлэн ажиллаж байна. Мөн Төрийн үйлчилгээний ажилтан, албан хаагчдад ажлын үр дүнгээр олгох ур чадварын нэмэгдлийг сар бүр ажил дүгнэсэн үнэлгээгээр үндсэн цалингийн 25 хүртэлх хувиар бодож олгож байна.			100
Үнэлгээний дундаж				91,8%